



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 18 өдөр

Дугаар

A/273

Хэрлэн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, анги, хичээл бүрээр сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд нийцүүлэн баталсан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Шалгуур үзүүлэлт батлах тухай” А/180 дугаар тушаалыг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор бага ангийн багш нарын дунд зохион байгуулсан “Ээлжит хичээл ба хүмүүжлийн эерэг арга” сэдэвт цахим сургалт зохион байгуулах сургагч багшийн зардал 3,888,000 (гурван сая найман зуун наян найман мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн тухайн төсвийн жилийн явцад шинээр батлагдсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч дарга (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

20220518